



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Гишүүнчлэлийн журам”-ын 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 2014/10 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн 2014 оны 9 дүгээр сарны 1-ний өдрийн 1/451 тоот албан мэдэгдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу үүргээ биелүүлээгүй хавсралтад заасан нэр бүхий 12 компанийн арилжаанд оролцох эрхийг 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн холбогдох журам болон гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд хязгаарлах арга хэмжээ авсугай.
2. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газрын даргын үүрэг гүйцэтгэгч /М.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР



Гүйцэтгэх захирлын 2014 оны 10 дугаар  
сарын 1-ний өдрийн /11/ тоот  
тушаалын хавсралт

**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг  
хязгаарлах гишүүн компаниудын жагсаалт**

Д/д	Гишүүн БДК-ийн нэрс
1	Ай трейд
2	Би Би Эс Эс
3	Гранддевелопмент
4	Грийт Секьюритис
5	Ди Си Эф
6	Догсон
7	Зэт Жи Би
8	Зюс Капитал
9	Масдак
10	Очир-Эрдэнэ инвест
11	Соёмбо инвестмент корпораци
12	Эф Си Икс